



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шивээхүрэн дэх гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2025/022/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2025 он</p>	<p>Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 82
танай _____-ны № _____-т

ШИВЭЭХҮРЭН ДЭХ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА М.ӨНӨРБУЯН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шивээхүрэн дэх гаалийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 106,788.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй “Нутгийн дэм” хөтөлбөрийн хүрээнд байгууллагын албан хаагчдыг хамруулж 166,394.9 мянган төгрөгийн дэмжлэг, төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг 25 хувиар буюу 33,521.2 мянган төгрөгийн нэмэгдэл олгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний

4625020187

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Досх

хэрэгжилтийг 83.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>238,402,875.71</u>	<u>413,994,797.89</u>
33	АВЛАГА	346,401.00	396,863.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	50,462.18
335	Бусад авлага	346,401.00	346,401.00
3351	Байгууллагаас авах авлага	346,401.00	346,401.00
35	БАРАА МАТЕРИАЛ	238,056,474.71	413,597,934.71
35300	Бэлэн бүтээгдэхүүн	52,605,180.00	52,467,780.00
354	Хангамжийн материал	185,451,294.71	361,130,154.71
35410	Бичиг хэргийн материал	638,200.00	2,509,100.00
35420	Аж ахуйн материал	48,021,900.00	88,893,610.00
35430	Сэлбэг хэрэгсэл	46,479,340.00	51,844,590.00
35440	Түлш, шатах тослох материал	6,763,800.27	32,163,800.27
35450	Барилгын засварын материал	26,135,800.00	26,135,800.00
35470	Бусад хангамжийн материал	57,412,254.44	159,583,254.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,207,204,012.49</u>	<u>9,400,109,006.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,207,204,012.49	9,400,109,006.50
392	Биет хөрөнгө	11,047,258,637.92	9,263,229,506.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,950,962,875.75	3,058,565,483.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	(470,693,489.76)	(560,117,915.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	284,500,000.00	284,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(219,500,000.16)	(241,166,666.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,300,246,353.83	11,547,459,764.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,798,257,101.74)	(4,826,011,160.39)
393	Биет бус хөрөнгө	159,945,374.57	136,879,500.09
39301	Программ хангамж	3,891,800.00	3,891,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,837,550.01)	(2,508,550.05)
39303	Бусад биет бус хөрөнгө	211,613,621.11	211,613,621.11
39304	Хуримтлагдсан элэгдэл	(53,722,496.53)	(76,117,370.97)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,445,606,888.20</u>	<u>9,814,103,804.39</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>346,401.00</u>	<u>9,253,614.68</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	346,401.00	9,253,614.68
413	Өглөг	346,401.00	9,253,614.68
4136	Бусад өглөг	346,401.00	9,253,614.68
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	346,401.00	346,401.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	399,004.88
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	-	8,508,208.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,445,260,487.20</u>	<u>9,804,850,189.71</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,115,319,788.52	2,115,319,788.52
512	Хуримтлагдсан үр дүн	8,571,498,145.69	6,931,087,848.20
51210	Өмнөх үеийн үр дүн	10,054,714,832.41	8,571,498,145.69
51220	Тайлант үеийн үр дүн	(1,483,216,686.72)	(1,640,410,297.49)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	758,442,552.99	758,442,552.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,445,606,888.20</u>	<u>9,814,103,804.39</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,269,982,464.00	3,997,176,741.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	132,390,304.00	190,706,451.00
120	Нийтлэг татварын бус орлого	132,390,304.00	190,706,451.00
120005	Түрээсийн орлого	5,997,000.00	7,056,000.00
120009	Бусад орлого	126,393,304.00	183,650,451.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,137,592,160.00	3,806,470,290.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,107,073,900.00	3,606,194,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,107,073,900.00	3,606,194,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,518,260.00	200,276,290.68
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,518,260.00	200,276,290.68
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,359,319,953.92	5,864,853,450.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,359,319,953.92	5,864,853,450.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,157,624,281.75	5,501,091,074.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,497,206,947.98	2,710,079,044.57
210101	Үндсэн цалин	852,963,351.71	1,312,173,165.78
210102	Нэмэгдэл	423,435,732.23	653,246,222.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	89,628,500.00	337,080,500.00
210104	Урамшуулал	131,179,364.04	407,579,155.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	187,512,648.77	338,792,557.43
210201	Тэтгэврийн даатгал	128,555,225.28	228,471,492.79
210202	Тэтгэмжийн даатгал	15,011,164.06	27,361,790.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,457,412.65	18,142,719.53
210204	Ажилгүйдлийн даатгал	2,871,622.38	12,963,310.81
210205	Эрүүл мэндийн даатгал	28,617,224.40	51,853,243.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,475,081.39	118,113,687.95
210301	Гэрэл, цахилгаан	104,164,361.39	109,968,493.97
210302	Түлш, халаалт	41,100,000.00	8,145,193.98
210303	Цэвэр, бохир ус	210,720.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	34,726,284.06	32,576,839.24
210401	Бичиг хэрэг	5,411,920.00	4,604,900.00
210402	Тээвэр, шатахуун	27,529,100.06	24,995,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	643,664.00	1,074,468.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	61,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,080,000.00	1,896,820.00
210408	Бараа материал акталсны зардал		5,451.00
2105	Нормативт зардал	5,000,000.00	1,936,120.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,000.00	1,936,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,774,014.50	43,154,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,065,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	43,150,729.50	1,719,500.00
210604	Урсгал засвар	27,623,285.00	40,369,600.00
2107	Томилолт, зочны зардал	788,000.00	2,372,000.00
210702	Дотоод албан томилолт	788,000.00	2,372,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,856,632.50	83,274,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	699,775.00	

Шивээхүрэн дэх гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	279,600.00	272,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	88,000.00
210807	Газрын төлбөр	1,440,000.00	1,440,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	82,437,257.50	81,474,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,131,284,672.55	2,170,792,025.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,881,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,131,284,672.55	2,161,911,025.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,695,672.17	363,762,375.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	109,756,260.00	238,882,199.96
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	218,382,199.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	109,756,260.00	20,500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,939,412.17	124,880,176.03
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,939,412.17	124,880,176.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,089,337,489.92)	(1,867,676,708.63)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,089,337,489.92)	(1,867,676,708.63)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,146,659,160.00</u>	<u>3,818,230,290.68</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,067,000.00	11,760,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,067,000.00	11,760,000.00
120005	Түрээсийн орлого	9,067,000.00	11,760,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,137,592,160.00	3,806,470,290.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,107,073,900.00	3,606,194,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,107,073,900.00	3,606,194,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,518,260.00	200,276,290.68
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,518,260.00	200,276,290.68
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,103,567,460.00</u>	<u>3,690,680,682.68</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,103,567,460.00	3,690,680,682.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,901,871,787.83	3,322,214,306.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,496,643,276.14	2,706,202,089.95
210101	Үндсэн цалин	741,282,849.11	1,176,677,530.64
210102	Нэмэгдэл	486,337,202.26	714,860,091.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	120,392,224.77	387,714,079.94
210104	Урамшуулал	148,631,000.00	426,950,387.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,337,386.30	333,812,760.55
210201	Тэтгэврийн даатгал	134,530,627.76	235,402,516.76
210202	Тэтгэмжийн даатгал	11,452,520.98	28,181,133.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,082,736.83	19,369,138.05
210204	Ажилгүйдлийн даатгал	2,208,873.91	10,375,112.22
210205	Эрүүл мэндийн даатгал	29,062,626.82	40,484,860.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,115,081.39	148,508,887.95
210301	Гэрэл, цахилгаан	104,164,361.39	109,968,493.97
210302	Түлш, халаалт	39,740,000.00	38,540,393.98
210303	Цэвэр, бохир ус	210,720.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	27,926,984.00	29,447,088.24
210401	Бичиг хэрэг	4,552,620.00	6,475,800.00
210402	Тээвэр, шатахуун	21,589,100.00	20,000,000.00

Шивээхүрэн дэх гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	643,664.00	1,074,468.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	61,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,080,000.00	1,896,820.00
2105	Норматив зардал	5,000,000.00	1,798,720.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,000.00	1,798,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,641,685.00	89,391,660.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,702,340.00	1,065,600.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,156,600.00	1,719,500.00
210604	Урсгал засвар	29,782,745.00	86,606,560.00
2107	Томилолт, зочны зардал	788,000.00	2,372,000.00
210702	Дотоод албан томилолт	788,000.00	2,372,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,419,375.00	1,800,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	699,775.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	279,600.00	272,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	88,000.00
210807	Газрын төлбөр	1,440,000.00	1,440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,881,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,881,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,695,672.17	368,466,375.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	201,695,672.17	363,762,375.99
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	218,382,199.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	201,695,672.17	145,380,176.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,704,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,704,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>43,091,700.00</u>	<u>127,549,608.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	43,091,700.00	127,549,608.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,115,319,788.52	758,442,552.99	10,054,714,832.41	12,928,477,173.92
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,115,319,788.52	758,442,552.99	10,054,714,832.41	12,928,477,173.92
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,483,216,686.72)	(1,483,216,686.72)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,115,319,788.52	758,442,552.99	8,571,498,145.69	11,445,260,487.20
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,115,319,788.52	758,442,552.99	7,088,281,458.97	11,445,260,487.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,115,319,788.52	758,442,552.99	8,571,498,145.69	11,445,260,487.20
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,640,410,297.49)	(1,640,410,297.49)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,115,319,788.52	758,442,552.99	6,931,087,848.20	9,804,850,189.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,715,995,000.00	3,685,976,682.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,715,995,000.00	3,685,976,682.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,385,995,000.00	3,322,214,306.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,619,000,000.00	2,706,202,089.95
210101	Үндсэн цалин	1,150,000,000.00	1,176,677,530.64
210102	Нэмэгдэл	681,000,000.00	714,860,091.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	388,000,000.00	387,714,079.94
210104	Урамшуулал	400,000,000.00	426,950,387.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	333,625,000.00	333,812,760.55
210201	Тэтгэврийн даатгал	234,215,000.00	235,402,516.76
210202	Тэтгэмжийн даатгал	29,415,000.00	28,181,133.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,270,000.00	19,369,138.05
210204	Ажилгүйдлийн даатгал	10,145,000.00	10,375,112.22
210205	Эрүүл мэндийн даатгал	40,580,000.00	40,484,860.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,840,000.00	148,508,887.95
210301	Гэрэл, цахилгаан	111,000,000.00	109,968,493.97
210302	Түлш, халаалт	50,000,000.00	38,540,393.98
210303	Цэвэр, бохир ус	840,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	30,300,000.00	29,447,088.24
210401	Бичиг хэрэг	6,500,000.00	6,475,800.00
210402	Тээвэр, шатахуун	20,000,000.00	20,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,074,468.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,100,000.00	1,896,820.00
2105	Нормативт зардал	1,800,000.00	1,798,720.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,800,000.00	1,798,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	220,600,000.00	89,391,660.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,200,000.00	1,065,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,400,000.00	1,719,500.00
210604	Урсгал засвар	215,000,000.00	86,606,560.00
2107	Томилолт, зочны зардал	5,300,000.00	2,372,000.00
210702	Дотоод албан томилолт	5,300,000.00	2,372,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,630,000.00	1,800,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	700,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	580,000.00	272,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	-
210807	Газрын төлбөр	2,000,000.00	1,440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,900,000.00	8,881,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,900,000.00	8,881,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	330,000,000.00	363,762,375.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	330,000,000.00	363,762,375.99
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	100,000,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	230,000,000.00	218,382,199.96

Шивээхүрэн дэх гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	145,380,176.03
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,715,995,000.00	3,606,194,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,715,995,000.00	3,606,194,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,715,995,000.00	3,606,194,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 195,516.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 195,516.7 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнг үндсэн хөрөнгийн тодруулга тайлантай тулган баталгаажуулахад 9,334.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн гарт олгох цалингийн зардлын дүн өглөгийн тодруулга тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 10,627.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 30,666.6 мянган төгрөгөөр төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 127,549.6 мянган төгрөгөөр төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайлангийн богино хугацаат өр төлбөрийн дүнг өглөгийн тодруулга тайлангийн дүнтэй тулган баталгаажуулахад 17,108.1 мянган төгрөгөөр төгрөгийн илүү тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайлангийн авлагын дүнг авлагын тодруулга тайлангийн дүнтэй тулган баталгаажуулахад 230.7 мянган төгрөгөөр төгрөгийн илүү тайлагнасан нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 195,516.7 мянган төгрөгөөр залруулав.

Аудитаар 3 зөрчил² илэрсэнд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт-1: Тайлант онд 12 айлын албан хаагчдын орон сууцанд гадна фасадын их засвар хийж капиталжуулан бүртгэлд тусгасан байгаа боловч уг барилга байгууламж нь тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд байхгүй байна.

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн "иж бүрэн байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа хөрөнгийн бүртгэлд хяналт хэрэгжүүлэн ажил зохион байгуулах

Илрүүлэлт-2: Тайлант хугацаанд бараа материалын зарцуулалтын тайланг гаргахдаа шаардах хуудсыг байгууллагын дарга, нягтлан бодогч бүрэн хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал "Маягт, заавар батлах тухай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж бараа материалын зарцуулалтын тайлангийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

Илрүүлэлт-3: Тайлант онд байгууллагын даргын 2024 оны А/13 дугаар тушаалаар баталсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооцоо бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4-д "Тооллогын комисс дараах үүрэгтэй", 4.4-д "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогын комиссын ажлын үр дүнг сайжруулан, хөрөнгийн хяналт, хадгалалт, хамгаалалтыг дээшлүүлэн ажиллах

Илрүүлэлт-4: Тайлант онд биеийн тамирын уралдаан, тэмцээний зардлаас 4,381.0 мянган төгрөгийн тамирын хувцас худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэйгээр зарцуулан ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнг үндсэн хөрөнгийн тодруулга тайлантай тулган баталгаажуулахад 9,334.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	9,334.4	1	9,334.4	-	-	1	9,334.4	-	-	-	-
2	Мөнгөн гүйлгээний тайлангийн гарт олгох цалингийн зардлын дүн өглөгийн тодруулга тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 10,627.1 дутуу тайлагнасан	1	10,627.1	1	10,627.1	-	-	1	10,627.1	-	-	-	-
3	Бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 30,666.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	30,666.7	1	30,666.7	-	-	1	30,666.7	-	-	-	-
4	Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 127,549.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	127,549.6	1	127,549.6	-	-	1	127,549.6	-	-	-	-
5	Санхүүгийн байдлын тайлангийн богино хугацаат өр төлбөрийн дүнг өглөгийн тодруулга тайлангийн дүнтэй тулган баталгаажуулахад 17,108.1 мянган төгрөгийн илүү тайлагнасан	1	17,108.1	1	17,108.1	-	-	1	17,108.1	-	-	-	-
6	Санхүүгийн байдлын тайлангийн авлагын дүнг авлагын тодруулга тайлангийн дүнтэй тулган баталгаажуулахад 230.8 мянган төгрөгийн илүү тайлагнасан	1	230.8	1	230.8	-	-	1	230.8	-	-	-	-
	Дүн	6	195,516.7	6	195,516.7	-	-	6	195,516.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд 12 айлын албан хаагчдын орон сууцанд гадна фасадын их засвар хийж капиталжуулан бүртгэлд тусгасан байгаа боловч уг барилга байгууламж нь тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд байхгүй байна	1	-					1	-				
2	Байгууллагын даргын 2024 оны А/13 дугаар тушаалаар баталсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооцоо бодоогүй байна.	1	-					1	-				
3	Тайлант хугацаанд бараа материалын зарцуулалтын тайланг гаргахдаа шаардах хуудсыг байгууллагын дарга, нягтлан бодогч бүрэн хөтлөөгүй байна.	1	-					1	-				
	Дүн	3	-					3	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардлаас 4,381.0 мянган төгрөгийн тамирын хувцас худалдан авсан байна.	1	4,381.0	-	-	-	-	1	4,381.0
2	Тээвэр шатахууны зардалд гүйцэтгэлээр 20,000.0 мянган төгрөг зарцуулахдаа худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
	Дүн	2	4,381.0	-	-	-	-	2	4,381.0